

“Хил хязгааргүй алхам” ТББ

“Хил хязгааргүй алхам” ТББ нь Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, менежементийн нөлөөллөөс хүрээлэн буй орчин, хүний эрхийг хамгаалах, сайн засаглалыг бүтээх үйл явцад талуудын оролцооны эрхийг хангах, чадавхыг бэхжүүлэх зорилгын хүрээнд иргэдийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, мониторинг, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус, нийгэмд үйлчилдэг байгууллага юм.

2016 оноос хойш хийж хэрэгжүүлсэн томоохон ажлууд:

2021 оны гол үр дүн, амжилт:

1. “Оксфордын их сургууль”-ийн Газар зүйн сургуулийн дэмжлэгтэйгээр **“Эрдэс баялгийн салбар түүний дэд бүтцийн төслийн нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал, журмын төсөл”** мөн эрх зүйн судалгаа, хэрэгцээний үнэлгээ судалгааг боловсруулж ЗГХЭГ-ын 2020 оны 28-р тушаалаар батлагдсан салбар дундын ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. Улмаар БОАЖЯ, ХНХЯ-ны сайдын хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулан тус ажлын хэсэгт ажиллаж байна.
2. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Элдэвийн бүлэг ордод түшиглэн тус сумын хэмжээнд уул уурхайн салбараас үүссэн хүний эрхийн зөрчилд **Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ** хийж эхэлсэн ба 2022 онд дуусгахаар байна.
3. Шведийн байгаль хамгаалах агентлагийн дэмжлэгтэй НҮБХХ-ийн **“Уул уурхайн салбарын Байгаль орчны засаглал”**-ыг сайжруулах хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр **“Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг”** аргачлал боловсруулж 2 аймгийн 3 суманд 4 төсөлд туршин сайжруулж гарын авлага, аргачлалыг Англи, Монгол дээр хэвлэн, 15 минутын харандааны зурган видео бүтээсэн.
4. АМТХ-ын 42-р зүйлийн дагуу уул уурхайн компани, нутгийн захиргаа хооронд байгуулдаг **Хамтран ажиллах гэрээ** байгуулахын өмнө ЗЕХ-ийн 26-р зүйлийн дагуу нөлөөллийн бүсийн иргэдийг оролцуулсан сонсох ажиллагаа хийгээгүй эс үйлдэхүй бүхий Дорноговь аймгийн нэг гэрээг жишиг болгон авч Захиргааны хэргийн шүүхэд үүсгэсэн маргаан 2 дох жилдээ эцэслэн шийдэгдэж **Эвлэрлийн гэрээ** байгуулсан болно.

5. НҮБХХ-ийн “Төлөөллийн байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр “Багийн ИНХ-ын хуралдааныг амжилттай удирдах нь гарын авлага”-ыг боловсруулах хамтарсан багийн ахлагчаар ажиллаж, 2022.01.01-ээс хэрэгжиж эхэлсэн “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгаар батлагдсан хуультай нийцүүлэн сайжруулж, тус гарын авлагыг 300 хувь хэвлэн түгээж байна.

6. МОНЭС-ийн Уур амьсгалын ногоон сангийн дэмжлэгтэй төслийн хүрээнд Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-тэй хамтран уул уурхайн төслийн нөлөөллийн бүсийн иргэд, ИНБ-ын ажилтнуудад зориулан Ашигт малтмалын болон байгаль орчны багц хуулийн хялбаршуулсан “Хуулиа мэдье, Эрхээ эдэлье” цуврал 3 гарын авлага боловсруулж тус бүрийг 500 хувь хэвлэн түгээж байна.

7. Говийн 4 аймгийн байгаль хамгаалах нутгийн иргэдийн үүсгэн байгуулсан зургаан ТББ, нэг малчдын бүлэгтэй хамтран 2021.09.25 нд “Говийн бүсийн байгаль хамгаалах сүлжээ” байгууллаа.

- Дорноговь аймгийн Айраг сумын 25, Даланжаргалан сумын 20, Хатанбулаг сумын 10, Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сумын 15, Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь сумын 14, Төв аймгийн Баянжаргалан сумын 15 иргэн нийт 100 шахам иргэдэд жилийн туршид тогтвортой, давтамжтай хүрч тэдний байгаль орчин, хүний эрхийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх замаар “Хүний эрхэд суурилсан хандлагатай байгаль орчны эрх зүйн зөвлөх”-үүд болгон бэлтгэж чадавхжуулан ХОБОМ /Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг” чадварт сургалаа. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгчдийн ашигт малтмалын болон Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх хүлээсэн үүргийн хэрэгжилтэд нутгийн захиргаа, компанийн төлөөлөлтэй хамтран баг болж “Зөрчлийн баримтыг хамтдаа олж тогтоон хүсч байгаа өөрчлөлт хийх үйл явц”-д суралцаж, дадлага ажилд суурилсан мэдлэг, чадварыг эзэмшүүллээ. Үүнд нийт 4 компани, 6 нутгийн захиргааны байгууллага хамтран ажилласан болно.

Цаашид “ХОБОМ” аргачлалыг илүү боловсронгуй болгож үндэсний болон ОУ-ын түвшинд түгээн дэлгэрүүлэх, улмаар албан ёсны механизм болгох хүртэл тогтвортой анхаарч ажиллах болно.

- Уул уурхай, байгаль орчин, УАӨ, хүний эрх, иргэдийн бодит оролцоог **“Бодитойгоор зөвлөлдөх зарчим”**-д суурилсан бодлого, нөлөөллийн уламжлалт ажлыг үргэлжлүүлсэн бөгөөд нутгийн захиргаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд байгуулах **“Хамтын ажиллагааны гэрээ”**-г байгуулахын өмнө нөлөөллийн бүсийн иргэд ЗЕХ-ын дагуу сонсох ажиллагаанд хэрхэн оролцох талаар Айраг, Даланжаргалан сумын 2 багийн 50 гаран иргэдэд тогтмол цахим/танхимын сургалт явуулснаар 2 үр дүнд хүрсэн.

Нэгдүгээрт: Хамтын ажиллагааны гэрээний Харилцааны хороонд иргэдийг оролцуулахад аймгийн ЗДТГ-аас анхаарч гэрээ байгуулахдаа заавал Хороо байгуулах, 2021 оноос эхлэн ХАГ байгуулахад иргэдээ эртнээс сонгож бэлтгэх тухай аймгийн Засаг даргын захирамж гарч Дорноговь аймгийн бүх сумдад хүргэгдсэн.

Хоёрдугаарт: Тус гэрээний байгаль орчныг хамгаалах тухай чиглэлд заалт тусгахад тухайн төслийн БОННУ-нд үндэслэн тусгадаг болохыг, улмаар шүүхийн маргаанд гэрээнд БО салбарын үүрэг хангалттай тусгагдаагүй, “хэрэгжээгүй болох асуудлаар маргаан үүсгэхэд компани түүний өмгөөлөгчид БОННУ түүний 5 жилийн БОМТ-д тулгуурлан маргаж байгааг олж мэдсэн нь томоохон сургамж болсон.

- Говийн бүсийн Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын нөлөөллийн хүрээг тэлэх ажлын эхлэл суурийг бэлтгэж Говьсүмбэр аймгийн “Хотол Чойр” ТББ, “ОНОШ” ТББ, Дорноговь аймгийн “Эх орон хамтын хүч” ТББ, “Айраг нутгийн эзэд” ТББ, Малчдын бүлэг, “Нутаг амь” ТББ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж Ази Номхон Далайн бүсийн 6 орны эмэгтэйчүүдийн ТББ-уудтай хамтран ажиллах сургалтад хамрагдаж **“Говийн бүсийн байгаль хамгаалах сүлжээ”** байгууллаа.

- Ашигт малтмалын хамгийн олон тусгай зөвшөөрөлтэй Дорноговь аймгийн Даланжаргалан сумын интернэт тогтмол ашиглах боломж бага малчид, иргэдэд бодит, дата шинжилгээ бүхий мэдээллийг хүргэх хэрэгцээг хангах, ОУИТБС-ын тайлан бусад дата эх үүсвэрээс нээлттэй байгаа уул уурхайн мэдээллийг хэрхэн сумын түвшинд ашиглаж болох загвар гаргах үүднээс **Охфордын их сургуулийн “Говийн загвар төсөл”**-ийн бүтээсэн гар утасны апплекейшныг докторант Б.Дэлгэрмаа, сэтгүүлч шинжээч З.Цэлмэг нарын оролцоотойгоор мэдээлэлд шинжилгээ, боловсруулалт хийж хүргэх, хууль тогтоомжийн ач холбогдол, үр нөлөөг таниулах www.mergenboodii.mn гар утасны апплекейшн боловсруулж, хөгжүүлэн нээлттэй болголоо.
- Охфордын Их сургуулийн дэмжлэгтэйгээр Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-тэй хамтран **“Малчдын газрын эрхийн хүүлийн хамгаалалт ба тогтолцоо”** сэдэвт судалгааны ажлыг амжилттай хэрэгжүүлж дуусч байна.


Зорилт 2. Байгаль орчноо хамгаалж, ирээдүй үеийнхээ эрхийг дээдлэх хүрээнд

хийгдсэн ажлууд:

- ☐ Уул уурхайн нөлөөллийн бүсийн иргэд, малчдад төслийн байгаль орчны мэдээллийг нээлттэй болгож бодитойгоор зөвлөлдөх эрхийг хүртээмжтэй болгох, иргэд-ИНБ мэдлэг- бодит баримттайгаар байгаль орчны хариуцлага нэхэх, утга учиртайгаар оролцох боломжийг хангасан арга хэрэгсэл болох Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг боловсруулж 2 аймгийн 3 суманд сургалт дадлага ажлыг амжилттай хэрэгжүүлсэн.
- ☐ Нутгийн захиргаа, нөлөөллийн бүсийн иргэд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хүрээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас үүссэн байгаль орчны бохирдол, доройтол, зөрчлийн талаар мэдэх эрхээ хэрэгжүүлэх, мэдээлэл-мэдлэгтэй болсон иргэд утга учиртай оролцооны цогц эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх замаар говийн бүсийн 4 аймгийн 8 сумын 150 гаран /74,6 эмэгтэй/ иргэдэд танхим/цахим хосолсон “Хүний эрхэд суурилсан хандлагатай байгаль орчны эрх зүйн зөвлөх”-үүдийг чадавхжуулан 15 Хүний эрхийн хамгаалагчдыг /9 нь эмэгтэй/ бэлтгэж байна.
- ☐ Ковид 19 цар тахалтай холбоотой олон нийт, уул уурхай бүхий нутгийн иргэд, ИНБ-д

чиглэсэн ФС:Хил хязгааргүй алхам төрийн бус байгууллага хаягаар, ХОБОМ хэрэгжүүлсэн 3 сум 2 аймагт ХОБОМ- Даланжаргалан; ХОБОМ- Баянжаргалан; ХОБОМ- Айраг сошиал нөлөөллийн ажил хэрэгжүүлсэн. Мөн UNDP in Mongolia - НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр facebook.com хаягаар сурталчиллаа.

□ Говийн бүсийн 4 аймгийн 8 сумын ИТХ-ын байгууллага болон нутгийн захиргаа, байгаль орчин болон газрын улсын байцаагч нарт уул уурхай, байгаль орчны хяналт хариуцлагыг хэрхэн хэрэгжүүлэх, бизнесээс хүний эрхийг хамгаалах төрийн үүргээ хэрхэн хэрэгжүүлэх талаар зөвлөгөө, сургалт өгч байна. Багийн ИНХ-ын хуралдааныг үр дүнтэй удирдах, сумын засаг дарга БОМТ-ний төлөвлөгөө, тайланг хэрхэн хянах зөвлөмж удирдамж, Хамтран ажиллах гэрээ байгуулахын өмнө Сонсох ажиллагаа хэрхэн зохион байгуулах, иргэд хэрхэн оролцох зөвлөмж аргачлал боловсруулж, сургалт зөвлөмж өгч байна.



“Хил хязгааргүй алхам” ТББ

“Хил хязгааргүй алхам” ТББ-ын
2006-2015 онд хийсэн зарим ажлуудыг онцолбол,

Хамтран ажилласан байгууллагын нэр	Төслийн нэр	Хугацаа	Хүрсэн үр дүн
НҮБ-ын МХЗ9 нэгж	“Хүний эрхийг баталгаажуулж, ардчилсан засаглалыг хөгжүүлэх”	2007-2009	Үүний үр дүнд тус суманд төр-хувийн хэвшил- иргэдийн тэгш оролцоотой Хөгжлийн түншлэл байгуулагдан ажиллаж байна.
ХААН БАНК САН	“Алслагдсан орон нутгийн эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхи, түүнийг нэмэгдүүлэх нь”	2008 - 2009	Говь-Алтай аймгийн Бигэр, Дэлгэр, Увс аймгийн Давст, Тэс, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумдын 100 гаруй эмэгтэйн 12 Өөртөө туслах бүлэг үүсгэн тэднийг чадавхижуулах шатанд ажиллаж байна.
Нээлттэй нийгэм форум	“Байгаль орчин уул уурхай ба хүний эрх” сэдэвт илтгэл бичих	2010 оны 02-03 сард	Ажлын хэсгийн ахлагч байгууллагаар ажиллаж илтгэлийг 2010 оны 04 сарын 19-нд НҮБ-ын ХЭ-ийн зөвлөлд хүргүүлж одоо нөлөөллийн ажил амжилттай явуулж байна
Дэлхийн банк, Нидерландын вант улсын Итгэлийн сан	Уул уурхайн үйлдвэрлэлийн явц дахь хуулийн хэрэгжилтэд иргэдийн оролцоо-хяналт”	2010.03-11сар	Увс аймгийн Тариалан, Өмнөговь аймгийн Цогтцэций, Дундговь аймгийн Баянжаргалан сумдад хэрэгжүүлсэн ба Иргэдийн Үнэлгээний карт нэртэй хяналт шинжилгээний шинэ механизм гарч байна
Дэлхийн банк Иргэний Нийгмийн Сан	Олборлох салбарт Олон Талт Хамтын Ажиллагааны гэрээ байгуулах нь	2010.06-11 сар	Олон Талт Хамтын Ажиллагааны Гэрээ байгуулах талуудад хандсан зөвлөмж гарын авлага боловсруулж байна
Швецарийн Хөгжлийн Агентлаг ТоБУУ төсөл	ХАМО иргэдийн Дууш мандал хайрхан ТББ-ыг чадавхижуулах нь	2010.08-12 сар	ТББ-ыг байгуулах, удирдан зохион байгуулах нь гарын авлага гарч байна ХАМО иргэд нөхөрлөл байгуулах гарын авлага боловсрогдож байна
Швецарийн Хөгжлийн Агентлаг	Орон нутгийн ТББ-уудыг чадавхижуулах	2011	
Хүний эрхийн үндэсний	Уул уурхай бүхий газруудад хүний эрхийн	2012	

комисс	үнэлгээ судалгаа хийх арга зүй боловсруулах	
Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	НӨУЁБ-аас уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах арга зүйн сургалт нөлөөлөл	2012
Монгол дахь “Жорж Соросын сан”	Газар чөлөөлж нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны эрхзүйн зохицуулалт Бодлогын судалгаа	2013,01-06
Швейцарийн хөгжлийн агентлаг	АМ-ын тухай хуульд Бичил уурхайн зохицуулалт оруулах Нөлөөллийн ажил хэсэг ахалж зохион байгуулах	2013 оны 01-02 сар
Нээлттэй нийгэм форум	ОУИТБС-Орон нутагт олон талт, нээлттэй хэлэлцүүлэг. Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций сумд	2014
Азийн сан	Хүний эрхэд суурилсан хандлагыг төрийн бодлого хөтөлбөр боловсруулахад нэвтрүүлэх нь сургагч багшийн гарын авлага боловсруулах, сургагч багш бэлтгэх	2014
Азийн сан	Байгаль орчныг хамгаалахад талоуудын оролцоог нэмэгдүүлэх сургалт Дундговь аймгийн 4 сум, Дорноговь аймгийн 2 суманд 2 үе шатлалт сургалт, нөлөөллийн ажил	2015
Азийн сан	Дундговь аймгийн 4 сум, Дорноговь аймгийн 2 суманд БОХ-х олон талт зөвлөл байгуулах сургалт, нөлөөллийн ажил	2015